



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/19

Хатан суудал

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт, Орон нутаг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны журмын 4.4.3 дахь заалт зэргийг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Сумын нутаг дэвсгэрт золбин нохой, муур устгах ажлыг 2022 оны 03 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Энхбат- Засаг даргын орлогч

Гишүүд:

Б.Амаржаргал- 5 дугаар багийн Засаг дарга

Л.Пүрэвсүрэн- Хэсгийн цагдаа

2.Нохой устгал хийхэд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат), Хэсгийн цагдаа (Л.Пүрэвсүрэн) нарт үүрэг болгосугай.

3.Нохой устгалын зардлыг Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4.Нохой, муур устгалын ажлын үр дүн, тайлан мэдээг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Энхбат)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642101345